

ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024.12.06

Хархорин

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (мян. төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
НЭГ. ОРОН НҮГГИЙН ХӨГЖИЛ, ТӨРИЙН УДИРДАГА							
Зорилт 1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
1.1	Арга хэмжээ-1 Хууль тогтоомж, Засгийн газар, болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах (Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (59.1.1)	500,0	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна.	Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг тухай бүр хяналтад авч ажиллалаа. 2024 онд Монгол Улсын хууль 9, Монгол Улсын Их Хурлын тогтоол 5, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 5, Ерөнхийлөгчийн зарлиг 6, Үндэсний ёюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл 3, Засгийн газрын тогтоол 33, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 6, Засгийн газрын албан даалгавар 1-ийг тус тус хяналтад авч, хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 96 хувьтай байна.	100
1.2	Арга хэмжээ-2 Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн сум орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг байгуулах					Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ	100

1.3	Арга хэмжээ-3 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн сүм орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах	5000,0	2023 оны хяналт Шинжилгээ, Үнэлгээний дүн		2024 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	сэргэлтийн "Бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөр, аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, арга хэмжээ бүрийг эзэнхүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. Тайланг журмын дагуу нэгтгэн гаргаж, холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан.	
1.4	Арга хэмжээ-4 Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн сүм орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах						
1.5	Арга хэмжээ-5 Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн сүм орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах						
1.6	Арга хэмжээ-6 Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний сүм орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах						
1.7	Арга хэмжээ-7 Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний сүм орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах						
1.8	Арга хэмжээ-8 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн	1000,0	Сургалтын тоо	54	57	Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний хүрээнд 69	100

	Мэргэжлийн Байгууллагатай ерөнхий гэрээ байгуулан Төрийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх		Цахим дэлгүүрээс худалдан авалт хийсэн тоо		Төрийн Байгууллагад ашиглагдах Байнгын хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнийг цахим дэлгүүрээс худалдан авсан байна.	Хугацаанд нь боловсруулж, гэрээг ажиглалаа.		
1.11	Арга хэмжээ-11 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас - ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэн харивуу өгөх, шийдвэрлэлтэд ахиц дэвшил гаргах		-Хуульд заасан хугацаанд шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй шийдвэрлэж, хариу өгсөн байдал -Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь нэгтгэн хүргүүлсэн байдал		Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг шуурхай шийдвэрлэж ажигласан байна.	Энэ онд Засаг даргын Тамгын газарт 3426 өргөдөл ирснийг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж хуулийн хугацаанд шийдвэрлүүлсэн. Өргөдөл, гомдол, саналын тайланг улирал бүр нэгтгэн гаргаж, холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан.	100	
Зорилт 2. Төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулан, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.								
2.1	Арга хэмжээ-12 www.khanhgoti.mn вэб сайт хөтлөлтийг сайжруулах, мэдээллийг тухай бүр нийтийн зар мэдээний самбаруудад байршуулах		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль -Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах		Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.	Нээлтэй мэдээллийг www.khanhgoti.mn вэб хуудас, Хархорин мэдээ фэсэбүүк, 8 цэгт байрлах нийтийн зар мэдээний самбарт нийтэлж, иргэдэд хүргэсэн. 2. Сул орон тооны зар мэдээллийг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тухай бүр хүргүүлж,	100	

		<p>ажилласан байдал</p> <p>-Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх" тухай 352 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал</p>	<p>шуурхай, чирэгдэлгүй хүргэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>зэргыг www.khaikhoim.mn вэб хуудас, Хархорин мэдээ фэсэбүүк хуудас, нийтийн зэр мэдээний самбаруудад байршуулж, сурталчилсан.</p> <p>3.Төсвийн гүйцэтгэлийн биелэлт, хягас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тухайн жилийн батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийг info.shlendans.gov.mn, www.khaikhoim.mn сайт болон 8 цэгт байрлах мэдээллийн самбарт тогтмол байрлуулан мэдээлэл хүргэж байна.</p> <p>4.Үзүүлж байгаа үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг ил тод байршуулсан.</p> <p>5.Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл зэрэг мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллалаа.</p>
--	--	---	---	---

2.2	<p>Арга хэмжээ-13 Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д нэвтрүүлсэн үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулж, хэрэглээг нэмэгдүүлэхэд зохихон байгуулалтын арга хэмжээ авч ажиллах</p>	-Иргэдэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар сурталчилж ажилласан байдал болон цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо	1276	<p>Төрийн үйлчилгээг авсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.</p> <p>-Цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.</p>	<p>Энэ оны жилийн эцсийн байдлаар Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс 76 төрлийн 1000 гаруй цахим үйлчилгээг үзүүлжээ. Үүнээс иргэний үнэмлэхний лавлагаа 45, жолоочийн үнэмлэхний лавлагаа 52, иргэний оршин суугаа хаягийн лавлагаа 110, зээлийн мэдээллийн лавлагаа 59, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 85, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа 72, төрлөсний бүртгэлийн лавлагаа 9 болон бусад төрлийн лавлагаа үйлчилгээгээр тус тус үйлчилгээ үзүүлсэн.</p>	100
2.3	<p>Арга хэмжээ-14 Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://egr.e-mongolia.mn/-ийг нэвтрүүлэх, мэдээлэл солилцох, албан бичиг солилцооны дундын системд холбогдох ажлыг эрчимжүүлэх</p>	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://egr.e-mongolia.mn/ -д нэвтэрсэн байгууллагын тоо	12	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://egr.e-mongolia.mn/ -д тухайн орон нутгийн төрийн байгууллагуудад бүрэн нэвтрүүлж ашиглаж хэвшсэн байна.	<p>38 төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч, архив, бичиг хэргийн эрхлэгч нарт EGR системийн талаарх сургалтыг зохихон байгуулж, төрийн 13 байгууллага EGR системийг нэвтрүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p>	100
2.4	<p>Арга хэмжээ-15 Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээ зохихон байгуулах</p>	-Арга хэмжээ зохихон байгуулсан тоо -Тоон гарын үсэг авсан иргэдийн тоо	1 1784	2 1000	<p>Энэ онд 1520 иргэнд тоон гарын үсэг олгосон. Төрөөс үзүүлж байгаа цахим үйлчилгээ, лавлагаа авахад иргэд тоон гарын үсэг ашиглаж хэвшээд байна. Татварын тасгаас "Цахимаар татвараа төлж, Цагаа хэмжээ" уриалгыг гаргаж, "Гэрэгэ" системийг ашиглах талаар видео контент хийж сурталчиллаа.</p>	100

2.5	<p>Арга хэмжээ-16 Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр аван үнэлж, түүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг төлөвлөж хэвшүүлэх</p>		Судалгаанд хамрагдсан иргэний тоо.	1000	Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч, үйл ажиллагаага сайжруулахад анхаарч ажиллаж байна.	100
2.6	<p>Арга хэмжээ-17 Аймгийн хэмжээнд Цахим хэлбэрт шилжсэн төрийн үйлчилгээг иргэд, олгон нийтэд сурталчлан таниулах, цахимгаар үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлэх</p>	1000,0	<p>-Цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо -Сурталчлан таниулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</p>	500 2	Цахимд хэвшье" нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, Нийгмийн даатгалын тасаг, Газрын алба, Татварын алба, Хөдөлмөрийн мэргэжилтэн, Мал эмнэлгийн тасаг, Улсын бүртгэл, Үүрэн холбооны операторууд, Хаан, Хас, Төрийн банкны салбарууд оролцон 432 иргэнд цахим үйлчилгээг танилцуулж, сурталчилсан.	100
<p>Зорилт 3.Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.</p>						
3.1	<p>Арга хэмжээ-18 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хүний нөөцийг чадваржуулж, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга харилцаагыг шалгуур болгох <i>(Төрийн албаны тухай хуулийн 55.3)</i></p>	5000,0	<p>-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдла -Төрийн албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчлийн (өсөлт, бууралт) тоо -Байгууллагын ёс зүйн зөвлөлт, дотоод хяналт</p>	Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үнэлж, дүгнэсэн байна.	Засаг даргын Тамгын газар нь 11 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ахиулан олгож, 3 албан хаагчид үр чадварын нэмэгдэл шинээр олгосон. Засаг даргын Тамгын газрын 45 (давхардсан тоогоор) албан хаагчдад 13,0 сая төгрөгийн илүү цагийн хөлс, 113,6 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт олголоо. Төрийн албаны зөвлөлгөөс 7 хоног бүрийн Пүрэв гаригт зохион байгуулдаг 7.4-10 цахим 27 удаагийн сургалтад нийт 356 төрийн албан хаагч хамрагдсан. "Монгол өрх" сэтгэлгүйн хүрээлэнгийн захирал, зөвлөх сэтгэл зүйч доктор С.Баасанбат багшийн Хөгжил-Сэтгэлийн	100

			<p>Шалгалтын ажлын чанар</p>	<p>Дархлаа лекц, "Атгасан гэр мэт хамт олон" сургалтад 45 төрийн албан хаагч хамрагдаж, сургалтын зардалд 1,5 сая төгрөг зарцууллаа.</p> <p>Дотоод хяналтын нэгжийг гишүүдийг "Эрсдлийг тодорхойлж удирдах арга зүй", "Дотоод хяналт шалгалт хийх арга зүй" сэдэвт сургалтад хамруулж, Байгууллагын эрсдлийг тодорхойлж, Дотоод хяналт шалгалтын журмыг шинэчлэн боловсруулсан.</p> <p>Дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу сүүлийн хагас жилд 4 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөмж өгч ажигласан.</p> <p>Засаг даргын Тамгын газрын дэргэд 3 гишүүний бүрэлдэхүүнтэй "Ёс зүйн дэд хороо" ажиглаж байна. Албан хаагчидтай холбоотой иргэдээс гомдол санал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг утас, цахимаар болон бичгээр авч ажигладаг. Тайлант хугацаанд ёс зүйн дэд хороонд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудалтай холбоотой гомдол ирээгүй байна.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар 1 удаагийн сургалт зохион байгуулж, 23 албан хаагч хамрагдсан.</p>
--	--	--	------------------------------	---

3.2	<p>Арга хэмжээ-19 Төрийн жинхэнэ албан тушаалын, болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тооны захиалгаа ирүүлэх, нэр дэвшүүлсэн иргэн, албан хаагчийг хууль тогтоомжийн хүрээнд томилох</p>	<p>-Сул орон тоог олон нийтэд ил тод мэдээлсэн байдал -Сул орон тооны захиалгыг хуулийн хүрээнд ирүүлсэн байдал -Зөрчилтэй томилоо хийгдээгүй байх -Тур орлон гүйцэтгүүлэх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн байх</p>	<p>Төрийн албаны томилоотой холбоотой шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна. Томилгоотой холбоотой томдод, маргаан гараагүй байна.</p>	<p>Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, Соёл аялал жуулчлал мэргэжилтний сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хургуулж, нэр дэвшүүлсэн 2 иргэнийг сул орон тоонд томилон ажиллуулж байна.</p>	100
3.3	<p>Арга хэмжээ-20 Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системийн хөтлөлт, мэдээллийн баяжилтыг тогтмол шинэчилж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр ханган, алдаатай мэдээллийг тухай бүр залруулах, системийн хамгаалалт, нууцлалыг хангаж ажиллах</p>	<p>-Баримт бичигтэй тулган үнэн зөв мэдээллийг бүрэн оруулсан байдал -Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үүрэгжүүлсэн байдал -Нууцлын баталгааг гаргуулсан байдал</p>	<p>Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"-ыг мөрдөж ажилласан байна.</p>	<p>Хүний нөөцийн мэдээллийн системд бүртгэлтэй 43 албан хаагчийн мэдээллийг бүрэн шинэчилж, өөрчлөлт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, зөрчилгүй ажиллаж байна. Сүүлийн хагас жилд ажилд орсон болон гарсан нийт 10 албан хаагчийн бүртгэлийг хийж, мэдээллийг бүрэн оруулсан.</p>	100
3.4	<p>Арга хэмжээ-21 Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах, сургалт хийх, ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах, мэргэшил арга зүйгээр хангах</p>	<p>-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах талаар зохион байгуулсан сургалтын тоо - Ёс зүйн дэд хорооны тоо</p>	<p>3 10</p>	<p>Сумын хэмжээнд төрийн 11 байгууллага ёс зүйн дэд хороог байгуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар Засаг даргын Тамгын газраас 2 удаагийн сургалт, Шүүхийн Тамгын газартай хамтран 4 байгууллагад тус тус сургалт</p>	100

ХОЁР.ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАР

Зорилт 4. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга хэлбэрээр зохион байгуулна.

						Зохион байгуулж, 190 төрийн албан хаагч хамрагдсан.	
4.1	Арга хэмжээ-22 Эрх зүйн сургалт, сурталчилгааны 2024 оны нэгдсэн төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах	1000,0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	90.0	95.0	Эрх зүйн сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд 69 удаагийн сургалт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 23 удаагийн лэйв, контент, подкаст, 4 удаагийн өдөрлөг, 19 төрлийн зурагт хуудас бэлтгэн ирээд, олон нийтэд хүргэсэн. Танхимын сургалтад 2048 иргэд, төрийн албан хаагч хамрагдаж, цахим сургалт, мэдээлгүүд нийт 100,000 гаруй удаагийн хандалтыг авсан байна. Хуулийн цаг подкастыг санаачлан хийж, 3 дугаар бэлтгэн ирэгдэд хүргэсэн нь нийт 10,1 мянган хандалт авсан. Төлөвлөгөөг 96,0 хувьтай хэрэгжүүлсэн.	100
Зорилт 5. Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сумдын төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх.							
5.1	Арга хэмжээ-23 Сумын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, тайлагнах. Цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	85.0	87.0	Авлигын эсрэг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг www.khalkhotg.gov.mn сайтад байршуулж, төрийн байгууллагууд авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, үр дүнт тооцон ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч ажиллагаа. Төлөвлөгөөний дүндэж биелэлт 2023 онд 87.5 хувьтай, 2024 онд 90.0 хувьтай буюу өмнөх оноос 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100

						<p>Хөтөлбөрийн тайланг нэгтгэн гаргаж, холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан. Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг талаарх мэдээллийг khaikholim.mn цахим хуудас, Хархорин мэдээ фэйсбүүк хаяг, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэн ажиллаж байна. Сум дундын Прокурорын газрын ерөнхий Прокурортой хамтран авлига, албан тушаалын гэмт хэрэг, хариуцлагын талаар сургалт зохион байгуулж төрийн байгууллагын 38 албан хаагчийг хамрууллаа. Мөн тус сэдвээр Хархорин мэдээ фэсбүүк хуудсаар лав хийж, 6,1 мянган удаагийн хандлагт авсан. Энэ онд авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно.</p>
5.2	<p>Арга хэмжээ-24 Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг томилохын өмнө (тур орлон болон хавсран, туршилтын хугацаагаар) Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах, томилогдсоны дараа 30 хоногийн дотор ХАСХОМ гаргах томилогдсоны дараа 30 хоногийн дотор ХАСХОМ</p>		<p>Хуулийн хугацаанд ХАСУМ хянуулсан болон ХОМ гаргасан албан тушаалтны хувь</p>	100	100	<p>Сум дундын Прокурорын газрын ерөнхий Прокурортой хамтран авлига, албан тушаалын гэмт хэрэг, хариуцлагын талаар сургалт зохион байгуулж, төрийн байгууллагын 38 албан хаагч хамруулсан. Сумын Засаг даргын орлогчийг томилохын өмнө Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, томилогдсоны дараа 30</p>

гаргах ажил хуулийн зөвлөлийг ажиглах.	Чиглэлээр тодорхой зохихон байгуулан, зөвлөлийн зөвлөлийг хэрэгжүүлж ажиглах.					Хөногийн дотор ХААСХОМ гаргуулсан.	
--	---	--	--	--	--	------------------------------------	--

ГУРАВ БАТЛАН ХАМГААЛАХ, ОНЦГОЙ БАЙДЛИЙН САЛБАР

Зорилт 6. Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

6.1	Арга хэмжээ-25 Цэргийн насны болон өсвөр насны залуучуудын дунд эх оронч үзэл, хүмүүжил олгоход чиглэсэн 2-оос доошгүй сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах	1000,0	Хамрагдсан иргэдийн тоо	-	100-аас доошгүй иргэнийг хамруулсан байна.	Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын 75 алба хаагчдад "Эх оронч хүмүүжил бидний бахархал" сэдэвт сургалт, үлгэлтийг зохион байгуулна. Мөн Батлан хамгаалах их сургуулийн доктор профессор Ч.Болдбаатар "Эх оронч хүмүүжил бидний бахархал" сэдэвт сургалт, үлгэлтийг зохион байгуулж, 300 гаруй хүүхэд, залуучууд хамрагдлаа. Насан туршийн боловсролын нэгжтэй хамтран цэргийн насны 18-25 насны залуучуудад "Эрүүл чийрэг эр хүн" эрүүл мэнд, амьдрах ухааны сургалтыг зохион байгуулан 35 залуу хамрагдсан.	100
-----	--	--------	-------------------------	---	--	---	-----

Зорилт 7. Иргэдэд Батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэж ажиллана. (Цэргийн бүртгэл, цэрэг татлага, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийх)

7.1	Арга хэмжээ-26 Ээлжит цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах, хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрт нь дэмжлэг тусалцаа үзүүлэх	2500,0	Цэрэг татлагад хамрагдах иргэд болон хяналтын тооны биелэлтийн хувиар	90	Цэрэг татлагад иргэдийн 90-ээс доошгүй хувийг хамруулан хяналтын тоог биелүүлнэ.	2024 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын захиралжаар байгуулж, цэрэг татлагад нийт 297 (1, 4 дүгээр дамжааны оюутнууд ороогүй) залуу орсноос 12 залуу цэргийн албанд тэнцсэн.	100
7.2	Арга хэмжээ-27 Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан, хааж болзлыг хангасан иргэдийн судалгааг	-	Мөнгөн төлбөр төлүүлэх хүний тоогоор	7	3-аас доошгүй иргэнээр мөнгөн төлбөр төлүүлсэн байна.	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж болзол хангасан иргэдийн судалгааг гаргаж, 2	70.0

ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАР

гартгаж, төлбөр төлүүлэх ажлыг зохион байгуулах	иргэнээр 2592000 төгрөгийн төлбөр төлүүлнэ.
<p>Зорилт 8. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн орлогыг төлөвлөх, улс, аймаг, сум, байгууллагын төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх, Татварын тухай хууль тогтоомжийг сурталчлан, хуулийн этгээдийг татвар төлөгчийн бүртгэлд бүрэн хамруулж, татварын бааз суурийг өргөтгөх ажлыг зохион байгуулна.</p>	
<p>8.1 Арга хэмжээ-28</p> <p>Аймгийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх</p>	<p>иргэдийн Хурлаар 1000,0</p> <p>Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын шилжүүлгийн биелэлт (мянган төгрөг)</p> <p>Орлогын төлөвлөгөөг 90.0-ээс дээш хувиар биелүүлнэ.</p> <p>Энэ онд аймгийн төсөвт 66,051,0 төгрөг төвлөрүүлэхээс 121,196,3 төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 183,4 хувиар давуулан биелүүлсэн.</p> <p>100</p>
<p>8.2. Арга хэмжээ-29</p> <p>Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг иргэдэд таниулж, хэрэгжилтийг ханган, орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх</p>	<p>Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь</p> <p>148.0</p> <p>Орлогын төлөвлөгөөг 90.0-ээс дээш хувиар биелүүлнэ.</p> <p>Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг иргэдэд сурталчилан таниулж, төсөвт 239,4 сая төгрөг төвлөрүүлсэн.</p> <p>100</p>
<p>Зорилт 9.Төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулан, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж, төсвийн жилд өр төлбөргүй ажиллана.</p>	
<p>9.1 Арга хэмжээ -30</p> <p>"Хоршоо хөгжүүлэх сан"-гийн эргэн төлөлтийг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах</p>	<p>Гэрээний хугацаа хэтэрсэн, найдваргүй зээлийн үлдэгдэл (төгрөг), гэрээний хугацаа хэтрэлт, найдваргүй зээлийн хувийн жин (хувиар)</p> <p>5.2</p> <p>Гэрээний хугацаа дуусгавар болсон, найдваргүй зээлийн үлдэгдлийг 30 хувиар бууруулж, гэрээний хугацаа дуусгавар болсон, найдваргүй зээлийн хувийн жин 4.7 хувьд хүргэсэн байна.</p> <p>Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/55 дугаар захирамжаар мах махан бүтээгдэхүүн ангилан ялгах, боловсруулах, малын тэжээл үйлдвэрлэл өргөтгөх чиглэлээр 2 хоршоонд 393,0 сая төгрөгийн зээл олгож, 12 түр болон байнгын ажлын байр бий болсон. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын баталсан 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн хяналт шалгалт зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу төсөл хэрэгжүүлж байгаа иргэн, аж ахуй нэгжүүдэд явцын үнэлгээг тусгай маягтын дагуу хийж, төслийн үр дүн, цаашид</p> <p>100</p>

9.2	<p>Арга хэмжээ -31</p> <p>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээлэл байршуулалтын чанарыг сайжруулах</p>		<p>Мэдээлэл байршуулалт, мэдээ илгээлт (хувиар)</p>	<p>99.0</p>	<p>Мэдээлэл байршуулалт, улирлын мэдээ илгээлтийг 100 хувьд хүргэсэн байна.</p>	<p>авах арга хэмжээний талаар мэдээлэл өгч ажигласан ба 98 хувийн биелэлттэй явагдаж, 37 зээлдэгчийн зээлийг бүрэн хөөлж, 25 зээлдэгчийн 41,2 сая төгрөгийн зээлийн ангиллыг солиулж, хугацаа хэтрэлт 1,1 хувьтай болсон. Зээлийн авлага 950,304,335 төгрөг, хуулийн авлага 77,942,273 төгрөг, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 270,282,927 төгрөг байна.</p>	9.3	<p>Арга хэмжээ-32</p> <p>Сангийн сайдын баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг хангаж, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлага систем олонлиаг.mof.gov.mn/-д мэдээллийг цаг тухайд нь байршуулах</p>	<p>Жилийн Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур</p> <p>Үзүүлэлтийн хувиар (70 хувиас дээш- 25 хувь урамшуулал, 90 хувиас дээш- 30 урамшуулал)</p>	<p>2023 оны үнэлгээ 82.4 хувь</p>	<p>Жилийн Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хувь өссөн байна.</p>	<p>ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем https://tusuv-olonliag.mof.gov.mn/-d 2024 оны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн төслийг бүрэн оруулсан.</p> <p>2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр нийт 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 634.9 сая төгрөг зарцуулсан.</p> <p>2025 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг нэгтгэн оруулсан.</p>	<p>100</p>			
<p>Зорилт 10. Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулна.</p>									10.1	<p>Арга хэмжээ-33</p> <p>Албан ёсны статистик мэдээ, тайланг графийн дагуу үнэн зөв цуглуулах,</p>	<p>-</p>	<p>-Графикт мэдээний тоо, чанар</p>	<p>100 хувь</p>	<p>Аймгийн Статистикийн даргын хэлтсийн даргын 2022 оны А/01</p>	<p>Аймгийн Статистикийн хэлтсийн даргын 2024 оны А/01 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу анхан шатнаас цуглуулах</p>	<p>100</p>

	хугацаанд нь программд оруулж буй эсэхэд хяналт тавьж ажиглах		-Программд хугацаанд нь шивсэн эсэх		дүгээр тшаалын 1 дүгээр хавсралтын дагуу хамралт 100 хувьтайгаар мэдээг үнэн зөв цуглуулж, хугацаанд нь программд шивж оруулсан байна.	статистик мэдээ, тайланг статистикийн тухай хуулийн дагуу сар бүрийн болон улирлын статистик мэдээ тайлан (ХАА-1, 8, СХ, АУ, ТББ, МЭ, ЗГ, Т, ББО, А-ОСЗ, А-ОС4, ХУИ)-г иргэн, аж ахуйн нэгж бүрээр цуглуулан программд шивж, статистикийн хэлтэст тухай бүр хургуулж ажиглалаа.		
10.2	Арга хэмжээ-34 Хүн ам, ерхийн мэдээллийн санг үнэн зөв хөтөлж, тогтмол баяжилт хийх		Хүн ам, ерхийн мэдээллийн санд засвар, өөрчлөлт хийсэн тоо	100 хувь	Сумын хүн ам, ерхийн мэдээллийн санд баяжилт хийж, шинээр төрсөн хүүхдийн мэдээллийг нэмж, нас барсан хүний мэдээллийг хассан байна.	Хүн, ам ерхийн мэдээллийн санд сум, багийн хүн ам, ерхийн мэдээллийн сангийн өрх, хүн амын үзүүлэлтийг тухай бүр үнэн зөв хөтөлж, тогтмол баяжилт хийж ажиглалаа. Энэ онд шинээр төрсөн нийт 142 хүүхдийг бүртгэж, нас барсан 70 хүний мэдээллийг программаас хассан.	100	
10.3	Арга хэмжээ-35 Угсаас явагдаж байгаа тооллого судалгаа болон хагас, бүтэн жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах, боловсруулах, үр дүнг мэдээлэх.		Тооллого, судалгааг хугацаанд нь чанартай зохион байгуулах, үнэн зөв бодит байдлыг хангах	100 хувь	Сумын нутаг дэвсгэрт байгаа мал, тэжээвэр амьтдыг жилийн эцсийн тооллогод хугацаанд нь 100 хувь хамруулж, үр дүнг боловсруулан, тархаасан байна.	Хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг зохион байгуулж, программд хугацаанд нь нэгтгэн оруулсан. Жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогыг 8 багийн 13 хэсэгт зохион байгуулж, нийт 62 төрийн албан хаагч ажигласан.	100	
ТАВ.ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ЖИЖИГ ДҮНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР								
Зорилт 11. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, сүргийн зохиистой бүтцийг хадгалах, түүхий эд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.								
11.1	Арга хэмжээ-36 Үржлийн болон цөм сүргийн мал, бор малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, анги чанарыг тогтоох, цөм сүрэг бүрдүүлэх, ялган		Үзлэг ангилалтад хамрагдсан малын тоогоор		Цөм сүргийн малыг ялган тэмдэглэж, мал аж ахуйн нэгдсэн системд бүрэн	Энэ онд 6 суурь дээр 931 хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлж, хуц-629 ухна-302-ийг үзлэг ангилалтад хамруулж, мал аж ахуйн нэгдсэн системд бүртгэсэн.	100	

	ТЭМДЭГЛЭЖ Мал аж ахуйн нэгдсэн системд хамруулах ажлыг зохион байгуулах. /airs.mofa.gov.mn/, /miz.gov.mn/-үүдэд мэдээллийн сан бүрдүүлэх				Хамруулсан байна.	Хоршоог хөгжүүлэх сангаас 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/55 дугаар захирамжаар мах махан бүтээгдэхүүн ангилан ялгах, боловсруулах, малын тэжээл үйлдвэрлэл өргөтгөх чиглэлээр 2 хоршоонд 393,0 сая төгрөгийн зээл олгож 12 түр болон байнгын ажлын байр бий болсон. Шинэ хоршоо-чинээлэг малчин хөдөлгөөний хүрээнд арилжааны банкаар дамжуулан 21 хоршоо малын тэжээл тариалах, хашаа саравч засварлах, малын үүлдэр угсаат сайжруулах, мал худалдаж авах, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах, арьс ширний анхан шатны боловсруулалтын чиглэлээр 3,269,360,000 төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, үйл ажиллагаа явуулж байна.	100
11.2	Арга хэмжээ-37 Эрчимжсэн болон туслах аж ахуй эрхлэгчдийг дэмжих, төсөл, хөтөлбөртэй хамруулах.	-	Дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн тоогоор	29	Эрчимжсэн аж ахуйн тоо өссөн байна.		
11.3	Арга хэмжээ-38 Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготногой микробиологийн болон	75500,0	Талбайн хэмжээ	1000	17.5 мянган га-д мэрэгч устгалын ажил зохион байгуулсан байна.	Сумын Засаг даргын "Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай" захирагждаар үлсвн төсвийн 100,7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 75,5 сая төгрөг, нийт 176,2 сая төгрөгийн санхүүжилтээр сумын Нарийн хүр, Жалбаа, Шанх багийн нийт 17,5 мянган га бэлчээрт 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 7 хуугацаанд	100

	энгийн механик Биологийн аргаар ургамал хамгааллын ажлыг зохион байгуулах					микробиологийн аргаар хөнөөлт мэргч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулж, 85,6 хувийн үр дүнтэй хүлээлгэн өгсөн. Мөн улсын төсвийн 9,2 сая төгрөгийн санхүүжилтээр 6658 га талбайд энгийн механик аргаар бэлчээрийн хөнөөлт мэргч амьтантай тэмцэх ажлыг 78.0 хувийн үр дүнтэй хийж гүйцэтгэсэн.	
Зорилт 12. Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, усалгаатай тариалан эрхлэх үйл ажиллагааг дэмжих							
12.1	Арга хэмжээ-39 Тариалалт, уринш Боловсруулалт, ургац хураалтыг технологийн хугацаанд гүйцэтгэх техникийн хангамж, шатах Тослох материалын нөөц бүрдүүлэх, ургацыг хамгаалах, ургацын зам засвар зэрэг ажлуудыг гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах		Арга хэмжээний дүнгээр	-	Арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	Тус онд 6520 га талбайд 3 төрлийн үр тарианы ургамал, 5200 га талбайд тосны ургамал, 2960 га талбайд тэжээлийн ургамал, 237 га талбайд төмс хүнсний ногоо нийт 14,8 мянган га талбайд тариалалт хийж, 5000 га талбайд урмишийн боловсруулалт хийлгэв. Дотоодын хэрэгцээний үр тариа 6790 га талбайд тариалж, 840 га талбай мөндөрт нэрвэгдэж, 50 га талбай тэжээлд шилжиж 5900 гагаас 4660 тн ургац хураан авч, 50 хувь, төмс 122 га талбайгаас 1098 тн ургац хураан авч 100 хувь, хүнсний ногоо 115 га талбайгаас 1092,5 тн хураан авч 60 хувь тус тус хангалаа. Хаврын тариалалт намрын ургац хураалтад 280 хүн ажиллалаа.	100
12.2	Арга хэмжээ-40 Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах		Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ га-аар		10 га талбайд ойн зурвас байгуулсан байна.	Тус онд 3 аж ахуйн нэгж, 2 иргэн 2 га талбайд 2000 ширхэг уулиас, хайлаас/ ойн зурвас шинээр байгуулсан. Мөн Эрдэнэсийн хотхон ХХК нь Оросын холбооны улсаас 2000 ширхэг олон төрлийн жимсний суулгад авчирч агро ойн аж ахуй,	70.0

						жймсний аж ахуй байгуулах эхлэл тавигдлаа.	
12.3	Арга хэмжээ-41 Тариалтангийн эргэлтийн талбайг нэмэгдүүлэх (тариалах талбай, хураан авах ургац, болговсруулах уриншийн төлөвлөгөөг хавсаргав)	Тариалсан талбай га, хураасан ургац тн-оор	5352 6860	Тариалалт, ургац хураалтын төлөвлөгөөний дагуу	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 21/03 дугаар Сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай тогтоолоор 127,6 га талбайг хоршоодод эзэмшүүлэхээр тогтоож, 6 хоршоонд 30 га талбай олгосон. Мөн Шанх, Жалбаа баг шинээр 120 га талбайг малчдад тэжээлийн ургамал тариалах зориулалтаар олгож нийт 150 га-аар эргэлтийн талбайг нэмэгдүүлсэн.	Тус онд 6520 га талбайд 3 төрлийн ур тарианы ургамал, 5200 га талбайд тосны ургамал, 2960 га талбайд тэжээлийн ургамал, 237 га талбайд төмс хүнсний ногоо нийт 114811 га талбайд тариалт хийгдээд байна.	100
Зорилт 13. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын хэрэгцээ хангамжийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг дээшлүүлэх							
		1000,0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн	"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг	Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зарласан "Хүнсний аюулгүй байдал" 6		70,0

13.1	<p>Арга хэмжээ-42 Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын 2022 оны 606 дугаар захирамжаар батлагдсан хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах "Аймгийн 5 жилийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг орон нутагт хангаж ажиллах.</p>	Тухайн жилийн үр дүнгээр	сайжруулах" 5 жилийн төлөвлөгөөг боловсруулан, сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	сарын авны хүрээнд хамтарсан хяналт шалгалт зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж, нийтийн хоол үйлдвэрлэл эрхлэгч, Үйлдвэрлэл СӨБбайгууллагын ажилчдад нийтийн хоол үйлдвэрлэлд тавигдах стандартын талаар сургалт зохион байгуулж, 34 иргэнийг хамруулсан. Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэдэд "Боломж" хүнсний бөөний төвд үзүүлэх сургалт зохион байгуулж нийт 42 иргэнийг тус тус хамруулсан. Мөн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэл, хүнсний цехүүдийн 85 хувьд хяналт шалгалт зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлгүй худалдаалж байсан 2 зөрчил, хадгалах хугацаа нь дууссан бүтээгдэхүүн худалдаалж байсан 5 зөрчлийг илрүүлэн торгуулийн арга хэмжээг авч ажилласан.	100
Зорилт 14. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.					
		26000,0 0	Хэрэгжилтийн хувь	99.0	<p>- Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 213937 мянган толгой малыг хамруулахаас жилийн эцсийн байдлаар 192859 мянган толгой малыг хамруулж 90 хувийн гүйцэтгэлтэй.</p> <p>- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 10 нэр төрлийн вакцинжуулалтын ажлыг зохион байгуулж 212,376 толгой мал</p>

14.1	Арга хэмжээ-43 : Мал амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд зохион байгуулах					хамрагдаж 99 хувийн гүйцэтгэлтэй байна. Гоц халдварт бог малын малзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 207,449 толгой бог малыг, Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 26,375 толгой үхрийг, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 178,318 толгой хонийг тус тус хамруулж 99 хувийн гүйцэтгэлтэй. Нийт давхардсан тоогоор 13 нэр төрлийн дархлаажуулалтанд 817,377 толгой малыг дархлаажуулж гоц халдварт өвчингүй тайван байдлаа хадгалж байна.	
------	--	--	--	--	--	--	--

ЗУРГАА.БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАГ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР

Зорилт 15. Ой, ан амьтныг хамгаалах чиглэлээр

15.1	Арга хэмжээ-44 Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор баталсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх	5000,0	-Тарьсан модны тоо, ургалтын хувь -Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн байдал	22390	127500	Бүх нийтээр мод тарих ажлыг 5, 10 дугаар сард зохион байгуулж, нийтийн эзэмшлийн талбайд 1260 ширхэг, тариалангийн талбайн хашаанд 3000 ширхэг, айл өрхүүд 4080 ширхэг, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн эзэмшил газартаа 6060 ширхэг, нийт 14400 ширхэг мод бут тарьлаа. Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх нээлттэй хаалттай 423 дугаар ангиас хандивласан 4080 ширхэг бүргэсэг сумын төвийн 800 өрхөд тарааж, мод тарихад шаардагдах 5 хово машин хар шороо бэлтгэж, мод тарих зөвлөмж мэдээлэл хүргэсэн.	100
------	---	--------	--	-------	--------	---	-----

Зорилт 16. Аялаг жуулчлалын талаар төрөөс баримтгах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, аялаг жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллана.

16.1	Арга хэмжээ-45 Орон нутгийн аялал хөгжүүлэх жуулчлалыг хүрээнд орчны бохирдол, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж ажиллах	16000 0,0	Стандартын шаардлагад нийцсэн хог хаях цэг, ариун цэврийн байгууламжийг бий болгосон байдал		Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн 124,9 сая төгрөг, Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр сумын нэгдсэн хотийн цэгийг ландшафтын аргаар буултах ажлыг Девсофт ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. Орон нутгийн хөгжлийн сангийн 15,8 сая төгрөгийн санхүүжилтээр сумын нэгдсэн хотийн цэгт 2 байршилд 5 ширхэг камер байршуулж, зориулалтын бус цэг хог хаягдал хаяхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа. Орхон голын эрэг дагуух малын сөг зэм хог хаягдлыг 5 хоногийн хугацаанд цэвэрлэж, 18 тнн хог хаягдлыг сумын төвийн нэгдсэн хотийн цэгт буулгасан. Орхон голын гүүрний баруун талд аялал жуулчлалд зориулсан 1 ариун цэврийн байгууламж барьсан.	70.0
ДОЛОО.ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАР							
Зорилт 17. Газрын харилцааны салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.							
17.1	Арга хэмжээ-47	1200,0	Мониторингийн цэгийн тоо		Сумын бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар ийн аргаар тодорхойлох	Бэлчээрийн өөрчлөлтийг газрын фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг ойт хээрийн бүсэд 7 цэг, хээрийн бүсэд 15 цэг нийт 22 цэгт хээрийн судалгаа хийж судалгааны үр дүнг харгалзан бэлчээр усжуулах, халгаалах, даацыг нь тохируулах ажлыг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. Онгоцон ухаа, Жалбаа, Шанх багийн 24168 га бэлчээрт хөнөөлт	100

	Сумын бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар үнэлэх, бэлчээрийн даац, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, чадавхыг тодорхойлох					Мэргэчтэй тэмцэх ажлыг зохион байгуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 16.0 сая төгрөгийн санхүүжилтээр Онгоцон ухаа, Орхон, Шанх, Жалбаа багт 8 бүлгийн эхийг халиж хамгаалж 4000 га бэлчээр усжууллаа. Багийн иргэдийн нийтийн хурлаар өвөл, хаврын бэлчээрийг чөлөөлөх тухай хэлэлцүүлж, батлуулсан 78979 га бэлчээрийг чөлөөлөж ажил зохион байгуулсан.	
17.2	Арга хэмжээ-48 Сумын Засаг дарга нарын 2003 оноос хойш гаргасан газрын харилцаатай холбогдуулан гаргасан эрх зүйн актад хяналт хийж газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж нөхөн бүрдүүлэх арга хэмжээг эцэслэн дуусгах	Захирамжийн тоо, нөхөн бүртгэж оруулсан нэрж талбарын тоо	Эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрд хяналт хийж газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргасан байна. Газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүртгэх арга хэмжээ бүрэн дууссан байна.	2003-2023 онуудад гарсан газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой болон газрын эрх шилжүүлсэн, мөн дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалтаар олгогдсон газар, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө түүний хэрэгжилт нэрж талбарын хувийн хэрэг үүссэн 8000 гаруй нэрж талбарт холбогдох журмын дагуу хяналт шалгалт хийж, алдаа дутагдал засварлах цахим хувийн хэрэг үүсгэх ажлыг шат дараатай хийж гүйцэтгэсэн. Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган нөхөн бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулаж 30 нэрж талбарыг нөхөн бүртгэж ГКМСанд бүрэн оруулсан.	100		
НАЙМ ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР							
Зорилт 18. Хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, хөдөлмөрийн аюулгүй орчныг бүрдүүлнэ.							
18.1.	Арга хэмжээ-49	Эмэгтэйчүүдийг чадавхжуулахад	Хөтөлбөрийн хэрэгжилтийг	Энэ онд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 3	100		

	"Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" аймгийн дэд хэрэгжилтийг хангах		Чиглэсэн мэдээлэл, сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж эмэгтэйчүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх		Ханган ажиллаж тайлагнасан байдал	эмэгтэйг хамруулж 7,1 сая төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд төслийн шаардлага хангасан 1 эмэгтэйг хамруулж, 2,0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон.	
18.2.	Арга хэмжээ-50 "Нэг өрх-нэг ажлын байр" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах		Өрхийн гишүүдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан өрхийг цоллоор нь хөгжүүлж, өрх бүрд ажлын байр бий болгох арга хэмжээг зохион байгуулах		Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна	Нийт 75 өрх хамрагддаг бөгөөд эдгээр өрхийн 48 иргэнийг нийтийг хамарсан ажилд, 2 төрлийн сургалтанд 13 иргэн тус тус хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 1 иргэн хамрагдаж, үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. /5,764,000 төгрөгийн санхүүжилт олгосон// 4 иргэн галч, 6 иргэн барилгын ажилд түр ажлын байранд ажиллаж байна.	70.0
Зорилт 19. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл хөтөлбөр, нийтлэг үйлчилгээний хүрээнд							
19.1	Арга хэмжээ-51 Ажилгүй иргэдийг ажлын байранд зуучлах		Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандарт, арга зүйн зөвлөмжийн дагуу ажил олгогчийн ажлын байрны захиалгын дагуу иргэдийг ажилд зуучлах	450	470	2024 онд орон нутгийн бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөр, хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлөгттэй эзэлд хамруулах, ажилд зуучлах замаар шинээр 103, түр ажлын байранд 106 иргэн зуучлагдаж, нийт 209 иргэн ажлын байраар хангагдсан байна.	100
Зорилт 20. Тэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалтын үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.							
		5000,0	Үйл ажиллагааны тоо	2 600	3 800	Сумын хүүхдийн төлөө зөвлөлөөс 2024 онд 2 удаагийн аян, 9 удаагийн сургалт, 6	100

20.1	<p>Арга хэмжээ-52 Хүүхдийн төлөө зөвлөл, залуучуудын төлөө хөгжлийн салбар зөвлөлтэй хамтран хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулах</p>	Оролцогч хүүхэд, залуучуудын тоо			<p>удаагийн хөгжил хамгааллын арга хэмжээг зохион байгуулж, 2000 гаруй хүүхдийг хамруулсан. Хүүхдийн төлөө зөвлөлөөс зохион байгуулсан мэдээ үйл ажиллагааг "Хархорин мэдээ" фэсбүүк хуудас болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн фэсбүүк хуудсаар эцэг, эх, олон нийтэд сурталчилан ажилласан. Smart book хөгжлийн төвд залуучын хөгжлийн салбар зөвлөлөөс ном хэрэглэгдэхүүн компьютер хандивлалаа.</p>	
20.2	<p>Арга хэмжээ-53 Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт нөлөөлийн үйл ажиллагааг зохион байгуулах</p>	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурсан байна		Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурсан байна	<p>2024 оны жилийн эцсийн байдлаар "Хүүхдийн эрхийн сургалт сурталчилгааны төв" ТББ-аас "Охидын хувийн хөгжил" сэдэвт түүвэр судалгаа, бүлгийн уулзалтад 40 сурагч, 10 асран хамгаалагч хамрагдлаа. 2023 оны байдлаар насанд хүрээгүй хүүхэд хохирсон 11 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2024 оны байдлаар 4 тохиолдол болон буурсан үзүүлэлтэй байна.</p>	70.0
<p>Зорилт 21. Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж, жөндөрийн салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-ний хэрэгжилтийг хангах, бүх нийтийн жөндөр ба эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн тусгалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулж ажиллана.</p>						
		1000.0	-Сургалт нөлөөллийн ажлын тоо -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	- 3 хүртэл - 80-100 хүн	<p>Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах" хууль тогтоомжийн хүрээнд 4 зорилт 23 зорилт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллагаа. "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд жөндөрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг 5 аж ахуйн нэгж байгууллага, 12 төрийн байгууллагуудын албан хаагчдад сурталчилан</p>	100

21.1	<p>Арга хэмжээ-54 Жөндөрийн салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, жөндөрт суурилсан хүүчрийлгээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээнд иргэд, олон нийтийг, зорилтот бүлгийг хамруулах, сүм бүр жөндөрийн дэд хороо байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах</p>					<p>ажилласан. Нийгмийн сүлжээнд эерэг зан нөлөөллийн мэдээллийг түгээж сурталчлан таниулав. Хархорин мэдээ болон www.khanhotul.mn сайтad аяны талаарх 3 төрлийн мэдээ, лого 3 сурталчилгааны материалуудыг байршуулж иргэдэд мэдээлэв. Төрийн албан байгууллагад ажилладаг эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоон мэдээ судалгааг гаргав. 31 төрийн байгууллагын 1081 төрийн албан хаагчаас 484 эрэгтэй, 597 нь эмэгтэй албан хаагчид байна. Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчид 43 үүнээс 22 эрэгтэй, 21 эмэгтэй албан хаагч байна. Жөндөрийн үндэсний хорооноос зарласан "Шалтаг бүү тооч" 16 хоногийн аянд нэгдэхийг төрийн байгууллаг, аж ахуй нэгж, иргэдийг уриаллав.</p>
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ						93,4

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Х.ЛХАГВАДУЛАМ